ЗБХТ-ны хүрээнд зуух эзэмшигч нь зуухны байгууламжийн талаархи мэдээллийг ирүүлсэнээр зуухны байгууламжийн байршил, нүүрс зарцуулалтын хэмжээг мэдэх бөгөөд ингэснээр УБ хотын хаанаас, ямар хэмжээний бохирдуулах бодис ялгарч байгааг таамаглан тооцоолох болох юм. Гэвч энэ нь зөвхөн бохирдуулах эх үүсвэрийн цэг байршил, тодорхойлон мэдэж байгаа төдий бөгөөд агаарын орчинд нөлөөлөх байдлын хэмжээ, түвшинг мэдэх боломжгүй юм. Иймд агаарын тархалтын загварчлалыг боловсруулан гаргаж, УХЗ-ны агаарын орчны агууламж дахь жишиг хувийг таамаглан тооцоолодог. Агууламжийн жишиг хувиас зуухны ялгарлыг багасгах зорилгоо тодорхойлж, түүнийг биелүүлэхэд чиглэсэн бодлогын саналыг боловсруулан хэрэгжүүлдэг. Бодлогын үр дүнд хэрэгжүүлэхийн өмнө болон дараа хийгдсэн тооноосон зэрэг бохирдуулах бодисын утааны хийн хэмжилтийн тоон үзүүлэлтээр үнэлдэг. Мөн суурин харуулын хэмжилтийн үзүүлэлтээр агаарын орчинг сайжруулах талаар хийгдэж буй бодлого, ажлын үр дүнд үнэлэх боломжтой юм. Үнэлгээний дүнд цаашид сайжруулах шаардлагатай зүйл байвал дараа онгоо бодлого, төлөвлөгөөнд тусган оруула. Ийм байдлаар хийгдэх ажлуудын эхлэл суурийг ЗБХТ-нь бүрдүүлж өгөх юм. Олон жилийн өөрчлөлтөөр мэдээллийг шинэчлэн, мэдээллийн нарийвчлалыг сайжруулснаар илүү оновчтой, зөв бодлого боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Зуух ашиглах зөвшөөрөл (үлгэр жишээ зуухаар тодорхойлох)


ЗБХТ-г нэвтрүүлсэнээр дараа шаардлагыг хангасан зууханд ашиглах зөвшөөрлийг олгож, мөн сайн ажиллагатай үлгэр жишээ зуухыг тодорхойлж байхаар зорилт тавьсан.

- A Зуухны бүртгэлийн маягт бөглөх үүрэг: Жил бүрийн 9 сарын 1-нээс өмнө бүртгэлийн маягтыг бөглөж, зуухны мэдээлэл ирүүлэх.
B Зуухны ажиллагааны сургалтанд хамрагдах үүрэг: Зуухны ажиллагааг хариуцагч зуухны галч нь зуухны сургалтанд оролцож батламж авах. Батламж нь 3 жилийн хугацаанд хүчинтэй.
C Төр захиргааны байгууллагаас хийгдэх утааны хийн хэмжилтийн хяналтанд хамрагдах үүрэг: Зуухны үйл ажиллагаа эрхлэгч (эзэмшигч) нь төр захиргааны байгууллагын ажилтан зуухыг хянах зорилгоор зуухны байгууламжид нэвтрэн орж утааны хийн хэмжилт зэрэг хяналт хийх үед зөвшөөрөн хүлээн авдаг байх. Мөн 2012 оны 10 сарын 1-нээс өмнө утааны хийн хэмжилтийн сорьцын цэг болон сорьц авах үед хүн зогсож ажиллах шат, тавианг бэлдсэн байх ба харилцан зөвшилцөх санааг бичгийн үйлдэн зуухны бүртгэлийн маягтай хамт Нийслэлийн Агаарын чанарын алба (НАЧА)-нд ирүүлэх.
D Утааны хийн хэмжилт болон тайлан гаргах үүрэг: Тусгайлан мэдэгдэх.
E Ялгарлын стандарт шаардлагыг баримтлах үүрэг: Зуухны үйл ажиллагаа эрхлэгч нь Монгол улсын стандартын зөвшөөрөгдөх хэм хэмжээг баримтлах ёстой.

Гэвч тус шинэ тогтолцоог бүрэн нэвтрүүлэхийн тулд төр захиргаа болон үйл ажиллагаа эрхлэгч талын техникчдийн үр дүнд болон хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа юм. Одоогоор эхний бэлтгэл шатанд А-С шаардлагыг хангасан үйл ажиллагаа эрхлэгчид зуух ашиглах зөвшөөрөл (үлгэр жишээ зуухаар тодорхойлох) -ийг олгох юм.

Яндангийн өндөрөөр ангилсан байдал

30 м хүрэхгүй өндөртэй яндан нийт яндангийн 89.1%-ыг эзэлж байгаа нь намхан яндан их байгааг харуулж байна. Ерөнхийдөө яндан өндөр байвал агаар бохирдуулах бодисын тархалт өргөн хүрээг хамарснаар агууламж нь (шингэрч) багаснаг. Харин яндан намхан бол утаа хангалттай сарниж тархдаггүй тул эх үүсвэрийн орчмын агууламж ихтэй болдог.



Төслийн хүрээнд зуухны утааны хийн хэмжилтийн багаж хэрэгслийг нийлүүлж, технологийн ур чадавхи эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. (Үр дүн 2) Хэмжилтийн үр дүнгээс харахад, утааны хийн агууламжийн хувьд зуухны марк, төрлөөс хамааралгүй зуухны галчын нүүрсээ түлэх арга барилаас хамаарч агууламж нь ихсэж, багасаж байгаа нь тодорхой болсон. Төсөлд энэ үр дүнд чухалчлан анхаарч зуухны бүртгэл, хяналт тогтолцооны хүрээнд зуухны ажиллагааны сургалтыг явуулж, түүнд галч болон зуухны үйл ажиллагааг хариуцагч нарыг хамруулж байхаар заасан. 2011 онд 3 удаа сургалтыг явуулж 124 хүн хамрагдсан бөгөөд оролцсон хүмүүст батламж гардуулсан. Тус батламж нь 3 жилийн хугацаанд хүчинтэй байх юм.



Зуухны ажиллагааны сургалт явагдаж буй байдал

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Цаашид 2011 онд бүртгэгдсэн мэдээлэл үндэслэн зуухны бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэх ба тус мэдээллийн санг ялгарлын инвентор, агаарын орчин дахь тархалтын загварчлал, орчны бодлогын санал боловсруулахад ашиглах юм. Мөн утааны хийн хэмжилтийн дүнг нэгтгэн оруулж, бусад холбогдох байгууллагуудад мэдээлэлээр хангах болно.

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатар дүүрэг 3, Улаанбаатар
Утас: 976-11-325939, 312393 Факс: 976-11-310845
http://www.jica.go.jp/mongolia/index.htm

Төслийн оффис

Хангард ордон, 4 давхар, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-9, Улаанбаатар (Нийслэлийн Агаарын чанарын алба (НАЧА))
Утас: 976-11-318551 Факс: 976-11-318551

Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл

Мэдээллийн тойм Vol.3 (2012 он 6 сар)
 Агаар бохирдуулагч бодис-Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор боловсруулалт

ЖАЙКА-н техник хамтын ажиллагааны төслийн товч агуулга

ЖАЙКА-ын техник хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл” нь 2010 оны 3 сараас эхэлсэн бөгөөд 2013 оны 3 сар хүртэл хэрэгжих төлөвлөгөөтэй байна.

Агаарын бохирдолд авах арга хэмжээг хэрэгжүүлэх төр захиргааны бүтэц, тогтолцоо хангалттай бүрэлдэгүй байгаа нөхцөл байдлыг харгалзан тус төслийн хүрээнд Нийслэлийн болон холбогдох салбарын байгууллагын боловсон хүчнийг бэлтгэж, агаарын бохирдолд авах арга хэмжээний чадавхийг бэхжүүлэхийг зорьж байгаа юм. Байгууллага тус бүрийн удирдлагын менежментийн чадавхийг бэхжүүлэн, холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулснаар агаарын бохирдолд авах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, цаашид бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээг бодитойгоор бууруулах боломжтой болох юм.

Төслийн үйл ажиллагаа

Тус төсөл нь дараах таван үр дүнд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Гарах үр дүн 1	Агаар бохирдуулагч бодисын эх үүсвэрийн инвенторыг боловсруулан, тархалтын загварчлалаар агаар орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.
Гарах үр дүн 2	ДИЦ болон УХЗ-ны утааны хийн хэмжилтийн технологийн үр чадавхийг эзэмшүүлнэ. (Зарим нэг гэрийн зууханд утааны хийн хэмжилт хийх)
Гарах үр дүн 3	Бохирдлын эх үүсвэрт хяналт тавих төр захиргааны тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлнэ.
Гарах үр дүн 4	ДИЦ болон УХЗ-нд эрчим хүч, дулаан хэмжээний оношлогоо хийж, агаарын бохирдолд авах арга хэмжээний саналыг өргөн барина.
Гарах үр дүн 5	Бусад хандивлагч байгууллага болон Монгол талаас хэрэгжүүлж байгаа агаарын бохирдолд авах арга хэмжээний хөтөлбөрт хувь нэмэр оруула.

Эдгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэнээр хамтрагч талын холбогдох байгууллагын агаар орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх чадавхи, бохирдуулагч бодисын ялгаруулалт болон түүнд авах арга хэмжээний хяналт, удирдлагын чадавхи, харилцааны болон менежментийн чадавхийг бэхжүүлж төлөвлөгөөтэй байна.

Энэхүү мэдээллийн тоймоор Гарах үр дүн 1-т багтсан хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторийн талаар танилцуулах болно.

Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор

“Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор” гэдэг нь

төслөөр хийсэн түлшний найрлагын шинжилгээний дүнгээс тодорхой болсон. Иймээс Рb-н ялгарлын коэффициентийг 0 гэж үзсэн.

Ялгарлын коэффициент нь зорчих хурднаас хамаарч өөрчлөгддөг. Жишээ нь түгжирээгүй үед 1км тутамд түлшний зарцуулалт нэмэгдэж, түүний үр дүнд SO₂-н ялгарлын хэмжээ ч нэмэгддэг. Улаанбаатар хотын замын 1,151км зорчих цаг тус бүрээр-замын төрөл тус бүрээр зорчих хурдыг тооцоолон ялгарлын коэффициентийг тооцоолсон.

Ялгарлын коэффициент нь адилхан овор хэмжээтэй автомашинд ч гэсэн үйлдвэрлэгдсэн стандартаас шалтгаалан ялгарлын хэмжээ ялгаатай байдаг. Улаанбаатар хотын автомашин бүрийн мэдээллийг ашиглан нэг бүрийн үйлдвэрийн стандарт гаргаж ялгарлын коэффициентийг баримжаалан тооцоолсон. Жишээлбэл нийслэлийн нийтийн тээвэрт явуулж байгаа Daewoo BS-106 загварын том оврын автобус нь 6-н төрлийн мотороос сонголт хийх боломжтой байдаг. 2009 онд шинээр худалдаж авсан 400-н автобус нь бусад мотортой харьцуулахад үйлдвэрийн стандарт сүл DE-12 загварын мотортойг сонгосноос болоод агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээ их болсон байдаг. Хэрэв чангаруулсан үйлдвэрийн стандарттай нийцсэн DL-08 загварын мотортойг сонгосон бол өртөг өндөртэй болох байсан байж боловч агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээ 30аас 80% багасгах байсан гэж бодож байна.

Агаар охирдуулагч бодисын ялгарлын хэмжээ

Хүснэгт-1-д тооцоолж гаргасан автомашинаас агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээг үзүүлээ. Гол зам дээрх ялгарлын хэмжээтэй оношилгоонд орсон тоог хүснэгт-2 үзүүлэх тээврийн хэрэгсэл бүрийн дундаж ялгаруулалтын хэмжээг тооцоолж гаргасан.

Хүснэгт-1 Тээврийн хэрэгсэлээ үүдэлтэй агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээ (Нийлбэр) (Нэгж: тн/ж) (2010 он)

Утаа	Гол зам	Хөнгөн тэрэг	NOx	PM-10	SO ₂	CO
			Том гарын хөнгөн тэрэг	2,612	8	55
		Тролейбус	786	29	44	5,691
		Том оврын автобус	0	0	0	0
		Жижиг ачааны машин	1,030	118	63	691
		Том оврын ачааны машин	239	17	21	575
		Бусад зам	445	27	20	1,032
		Замын тоос	1,674	65	67	10,479
		Нийт	6,786	9,530	270	42,478

Хүснэгт-2 Тээврийн хэрэгсэлээ үүдэлтэй агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээ (Нэг бүрийн дундаж) (Нэгж: кг/то/жил) (2010 он)

Утаа	Гол зам	Хөнгөн тэрэг	Төг	NOx	PM-10	SO ₂	CO
			Том гарын хөнгөн тэрэг	45,122	57.9	0.2	1.2
		Тролейбус	54,100	14.5	0.5	0.8	105.2
		Том оврын автобус	48	0.0	0.0	0.0	0.0
		Жижиг ачааны машин	1,469	700.9	80.5	43.1	470.1
		Том оврын ачааны машин	2,321	103.1	7.2	9.1	247.6
		Нийт	22,873	19.5	1.2	0.9	45.1

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Ялгарлын хэмжээг шинэчлэсэн. 2011 оны ялгарлын хэмжээг тооцоолхын тулд SHP-600 гэдэг түлшний шүүрний үр ашиг, дизель-газ хөдөлгүүрийн үр ашиг, Улаанбаатар хотын түлшний нийт

“Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор” гэдэг нь агаарын бохирдлын судалгаагаар мэргэшсэн мэргэжилтнүүдийн дунд, “Шилжилт хөдөлгөөн хийх үелээ агаар бохирдуулагч бодисыг ялгаруулагч зүйлс (авто машин, зүтгүүр (вагоны толгой), онгоц, усан онгоц)-ээс “Агаар бохирдуулагч бодисын хэмжээний данс бүртгэл” гэсэн утгатай. Улаанбаатар хотын хөдөлгөөнт эх үүсвэрийн хувьд автомашин нь гол эх үүсвэр болдог. Ийм учраас автомашинаас гарах агаар бохирдуулагч бодис болох нүүрсгөрөгч (CO), нүүрс устөрөгч (HC), хартуулга (Pb), хүхрийн давхар исэл (SO₂), азотын исэлүүд (NOx), тоос тоосонцор (PM) эдгээрийг хамруулдаг. Тээврийн хэрэгсэл нь Японоос эхлээд хөгжингүй болон хөгжиж буй орны олон хотуудад хамгийн том бохирдуулагч эх үүсвэр болж байдаг. Улаанбаатар хотын тухайд ч гэсэн одооноос арга хэмжээ авч эхлэх шаардлагатай байна.

Монголын агаар бохирдолд мэргэшсэн мэргэжилтэн нь “Хөдөлгөөнт эх үүсвэр” гэсэн мэргэжлийн нэр томьёоны үгийг зөв ойлгосон хүн олон байгаа боловч нөгөө талдаа энгийн иргэд “хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор”-ийг “автомашинны бүртгэл” гэсэн утгаар ойлгосон байх явдал цөөнгүй байдаг. Алдаатай буруу ойлголт үүсэхээс сэргийлж тохиромжтой үгээр илэрхийлж өөрчлөх шаардлагатай. Тийм тохиромжтой илэрхийлэх үгийг санал болгоорой.

Түүнчлэн “Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторын үйл ажиллагаа” нь автомашинаас ялгарах агаар бохирдуулагч бодисын хэмжээг тооцоолох үйл ажиллагааг хэлж байгаа юм.

Агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээг тооцоолох аргачлал

“Нэг автомашин 1км зам зорчих үед ялгаруулах агаар бохирдуулагч бодисын хэмжээг” ялгарлын коэффициент гэдэг. Олон тооны автомашиныг зориулах ялгарлын хэмжээг хэмжин түүний өгөгдөл датаанаас тооцоолсон коэффициент юм. Нэгж зай (уулзварын цэгээс нөгөө уулзварын цэгийг зайг хэлнэ) тутамд “Ялгарлын коэффициент” × “Нэгж зайн урт” × “Цагт зорчих тоо”-г тооцоолбол тэр нэгж зайнд 1 цагт ялгаруулах агаар бохирдуулагч бодисын хэмжээг тооцоож чадна. Улаанбаатар хотын нийт нэгж зайнд 24 цагийн 365 өдрийг тооцож нийлбэрийг гаргавал нийт ялгарлын хэмжээг бүтэн жилээр тооцоож гаргаж чадна.

Агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээг тооцоолох шат дараалал

Дараалал-1	Дараалал-2	Дараалал-3
Ялгарлын коэффициент	Аль нэг зам дээр 1 цагт ялгарах хэмжээ	Улаанбаатар хотын ялгарлын нийт хэмжээ
1 автомашин 1км зорчиход агаар бохирдуулагч бодис ялгаруулах хэмжээ	“Ялгарлын коэффициент” × “Нэгж зайн урт” × “Цагт зорчих тоо” гэсэн томъёогоор тооцоолох	Нэгж зай тус бүрийн ялгарлын хэмжээний нийлбэрийг тооцоолох
		

Ялгарлын коэффициент

Ялгарлын коэффициент нь тээврийн хэрэгсэлийн төрөл (Ачааны машин, жижиг тэрэг гэх мэт) болон түлшний төрөл (бензин, түлш, цахилгаан зэрэг)-ээс хамаарч томоохон ялгаатай байдаг. Тээврийн хэрэгсэлийн төрөл тус бүрээр зорчих тоог гаргаж, тухайн төрөл тус бүрээр ялгарлын хэмжээг тооцоолсны дараа нийлбэрийг гаргасан.

Ялгарлын коэффициент нь агаар бохирдуулагч бодисын төрөл тус бүрээр ялгаатай байдаг. Мөн түлшний химийн найрлагаас шалтгаалж өөрчлөгддөг. Жишээ нь Монголд худалдаалагдаж байгаа түлш болон бензинийг бусад олон оронтой харьцуулахад хүхрийн агуулмаас өндөр байна. Үүнээс болж Улаанбаатар хотын SO₂-н ялгарлын коэффициент нь өөр бусад орноос илүү том тоотой байна.

Нөгөөтэйгүүр, Улаанбаатар хотын бензинд хартуулга (Pb) агуулагдаагүй болхыг тус

Хөдөлгөөнт эх үүсвэрт авах арга хэмжээ түүний цаашдын хэрэгцээ шаардлага

2008-оос хойш цаг уур орчны шинжилгээний төв лаборатор болон НАЧА нь тасралтгүй хэмжих автомат суурин харуулыг ашиглаж эхэлсэн. Хадгалалдсан өгөгдөл 2010 оноос агаарын чанарын нарийвчилсан дүн шинжилгээ хийж чадахаар болсон.

ЦУОШЛ-ын 6 цэгт хийсэн агаар орчны бүтэн жилийн өгөгдлөөс харахад 4-н бодис стандартаас давсан байна.

SO ₂ , NO ₂ , PM-10, PM-2.5	Нийт цэгүүдэд MNS 4585 стандартын жилийн дундажаас давсан байна. MNS4585-н 24 цагийн дундажийг давсан цэг ч олон байна.
CO, O ₃	MNS 4585-н 8-н цагийн дундаж стандарт болон 1 цагийн дундажийг давсан үзүүлэлт бараг байхгүй. CO нь ихэссэн нь асуулал болоод байгаа тухай баримт байгаа бол хэлж өгнө үү. Үндэслэлгүй мэдээлэл юм уу эсвэл энэ хүснэгтийг өөрчлөн засварлах ёстой мэдээлэл юм уу гэдгийг нягталж үзье гэж бодож байна.

Замын ойролцоо газарт халаалтын бус улирал зун ч гэсэн NO₂ болон PM-10 ялгарах орчны стандартаас давсан байх тохиолдол олон байдаг. Ийм учраас тээврийн хэрэгсэлээс агаар NOx болон PM-10-н хэмжээг бууруулах ёстой.

Агаар бохирдуулагч бодисын зарваруулж загвараар тооцоолсон дүн дээр ч Улаанбаатар хотын ихэнх газарт SO₂ болон PM-10, NO₂ нь агаарын чанарын стандартаас давсан байгааг олж мэдсэн. Их тойруугаас туул гол орчмын газарт PM-10 болон NO₂ их байгаа шалтгаан нь тээврийн хэрэгсэлтэй холбоотой болхыг ойлгосон.

Илүү нарийн мэдээллийг 3/6-н семинарын материалаас үзээрэй.
<http://www.airquality.ub.gov.mn/index.php/en/2011-05-26-08-29-50/2012-03-23-01-08-58.html>

Улаанбаатар хотын тээврийн хэрэгсэл 10-30 жил ашиглагдаж байна. Өөрөөр 10-20 жилийн цадахыг урьдчилан харж авах арга хэмжээ судалж үзэхгүй бол болохгүй юм. Токно болон Осака хотуудад автомашинаас үүдэх агаарын бохирдол болхыг мэдсэн үедээ автомашины ялгаралтын хэмжээг бууруулах арга мэдэхгүй байсан. Техник технологид хөгжил гарч, автомашинаас үүдэх агаарын бохирдлыг арай гэж стандартаас доош буулгах хүртэл 40 гаруй жил шаардлагасан юм.

Одоо бол техник технологийг шинээр хөгжүүлэх шаардлагагүй юм. Харин Монгол Улс Япон зэрэг орны автомашинаас үүдэх агаарын бохирдлын туршлагыг зөв зүйтэй суралцаж хамгийн тохиромжтой арга хэмжээг хэрэгжүүлэн 10 жилийн дотор шийдвэрлэж чадах болов уу.

Шууд амархан хэрэгжүүлж чадах арга хэмжээ	Автомашинны засварын чанаржуулж, хүхрийн агуулмаас өндөр байсан ч эвдрэлтгүй PM бууруулалтын өндөр хувьтай DPF-г том оврын автобусанд суурилуулж, зам дээрх тоос шороог илүү ихээр багасгах зэрэг
Хэцүү боловч зайшгүй хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ	Хүхрийн агууламж багатай бензин дизелийг сонгож, Япон болон Европын цүүдийн үеийн ялгарлын стандартад нийцсэн автомашинд хөнгөлт өгөх, метр зэрэг нийтийн тээврийн байгууламжийг бий болгож түүний хэрэгцээг хөгжүүлэх зэрэг

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн гэгээр

Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-3 Боть намхаг 7 дугаар давхар
 Утас: 976-11-325939, 312933 Факс: 976-11-310845
<http://www.jica.go.jp/mongolia/index.htm>

Төслийн оффис

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-9 Хангарьд ордон 4-р давхар НАЧА (Нийслэлийн Агаарын Чанарын Алба)
 TEL: 976-11-318551 FAX: 976-11-318551

Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл

Мэдээллийн тойм Vol. 4 (2012 оны 6 сар)

ДЦС-ын үнсэн сангаас хийсэх агаар бохирдуулах бодисын эх үүсвэрийн инвентор боловсруулалт

ЖАЙКА-ын техник хамтын ажиллагааны төслийн товч агуулга

ЖАЙКА-ын техник хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл” нь 2010 оны 3 сараас эхэлсэн бөгөөд 2013 оны 3 сар хүртэл хэрэгжих төлөвлөгөөтэй байна.

Агаарын бохирдолд авах арга хэмжээг хэрэгжүүлэх төр захиргааны бүтэц, тогтолцоо хангалттай бүрэлдээгүй байгаа нөхцөл байдлыг харгалзан тус төслийн хүрээнд Нийслэлийн болон холбогдох салбарын байгууллагын боловсон хүчнийг бэлтгэж, агаарын бохирдолд авах арга хэмжээний чадавхийг бэхжүүлэхийг зорьж байгаа юм. Байгууллага тус бүрийн удирдлагын менежментийн чадавхийг бэхжүүлэн, холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулснаар агаарын бохирдолд авах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, цаашид бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг бодитойгоор бууруулах боломжтой болох юм.

Төслийн үйл ажиллагаа

Тус төсөл нь дараах таван үр дүнд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Гарах үр дүн 1	Агаар бохирдуулагч бодисын эх үүсвэрийн инвенторыг боловсруулан, тархалтын загварчлалаар агаар орчинд нөлөөлөх байдлын үнэмлэг хийнэ.
Гарах үр дүн 2	ДЦС болон УХЗ-ны утааны хийн хэмжилтийн технологийн үр чадавхийг эзэмшүүнэ. (Зарим нэг гэрийн зууханд утааны хийн хэмжилт хийх)
Гарах үр дүн 3	Бохирдлын эх үүсвэрт хяналт тавих төр захиргааны тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэнэ.
Гарах үр дүн 4	ДЦС болон УХЗ-нд эрчим хүч, дулаан хэмэлтийн оношлогоо хийж, агаарын бохирдолд авах арга хэмжээний саналыг өргөн барина.
Гарах үр дүн 5	Бусад хандивлагч байгууллага болон Монгол талаас хэрэгжүүлж байгаа агаарийн бохирдолд авах арга хэмжээний хөтөлбөрт хувь нэмэр оруулана.

Эдгээр үйл ажиллагаагааг хэрэгжүүлсэнээр хамтрагч талын холбогдох байгууллагын агаар орчинд нөлөөлөх байдлын үнэмлэг хийх чадавхи, бохирдуулах бодисын ялгаруулалт болон түүнд авах арга хэмжээний хяналт, удирдлагын чадавхи, харилцааны болон менежментийн чадавхийг бэхжүүлэх зорилготой юм.

Энэ дугаарт “Үр дүн-1”-ийн хүрээнд хийгдсэн ДЦС-ын үнсэн сангаас хийсэх агаар бохирдуулах бодис (АББ)-ын эх үүсвэрийн инвенторын талаар танилцуулая.

Хийсэлтийн хэмжилт

Дараах нөхцөл байдлыг харгалзан үзэж хэмжилтийн аргыг судалсан.


- 1) Үнэтэй багаж хэрэгсэл худалдан авах, томоохон судалгаа хийлгэх хөрөнгө мөнгө байхгүй тул мөнгө ихээр шаардагдах болон мэргэжилтэнд даалгаж хийлгэх аргыг сонгох боломжгүй.
- 3) Үнсэн сангийн сул үнстэй хийсч буй хэсгийн хувьд чийгтэй болохоор үнс нь нягтарч хатууралгүй тунаж тогтоод, гадаргын өнгөн хэсгээсээ хатаж эхлээд 10 жил болоогүй байгаа тул хөрс нь суусаар байх магадлал өндөртэй. Газрын гадаргын өндрийн өөрчлөлтийг хэмжих тохиолдолд хийсэлтийн хэмжээ ба хөрсний суултын нийт хэмжээг хэмжиж болох ч хөрс суултын хэмжээг хэмжих боломжгүй болохоор хийсэлтийн хэмжээг тооцоолж чадахгүй юм.
- 4) Салхинд элэгдсэн байдлаас харахад жилд хамгийн ихдээ 10 см орчим элэгдэж байгаа гэж үзэж байна. Жилд хэдэн мм-ээс 30 см хүртэл хэмжээнд элэгдэснийг хэмжиж чадвал хангалттай бөгөөд 1 мм хүрэхгүй нарийвчилсан хэмжилт хийх шаардлагатай юм.

Дээрх нөхцөлийг хангасан хэмжилтийн арга нь элэгдлийн дундаж зузааныг хэмжин, түүнийг талбайгаар үржүүлсэнээр тоос хийсэлтийн хэмжээг тооцоолж гаргадаг.

$$Q = S \times T \times D$$

Q	ялгарлын хэмжээ (тонн)
A	талбай (м ²)
T	элэгдлийн дундаж зузаан (м)
D	нягтрал (тонн/м ³)

Үнсэн санд олон төмөр гадсыг зоож тогтоогоод, сар болгон газраас дээш ил гарсан хэсгийн уртыг хэмжих ба гарсан хэмжилтийн өөрчлөлтийг элэгдлийн зузаан гэж үздэг.



Зураг. Элэгдлийн зузаан хэмжилтийн арга

ДЦС II, ДЦС III, ДЦС IV-ээс тус бүр хэмжилт хийх зөвшөөрөл хүсэж, ДЦС II, ДЦС III-аас зөвшөөрөл авсан.

ДЦС II-ын хувьд 2010 оны сүүлээс баруун талын үнсэн санд судалгаа хийж эхэлсэн. Төмөр гадасыг сайтар шааж зоогоогүйгээс 2011 оны хавар цас хайлах үед судалгааг үргэлжлүүлэх боломжгүй болсон хэдий ч 2011 оны намар төмөр гадасыг сэргээн зоож, хэмжилтээ дахин эхэлсэн.

ДЦС III-ын хувьд 2010 оны сүүлээс 4-р үнсэн санд хэмжилт хийж эхэлсэн. 2011 оны зун үнсэн санг хөрсөөр хучсан тул хучилт хийхээс өмнө 2011 оны хавар судалгааг түр зогсоож, 2011 оны намар хөрсөөр хучсаны дараа дахин хэмжилтийн судалгааг эхэлсэн.

2011 он хүртэл японы мэргэжилтний дэмжлэг, удирдлагаар хийгдэж байсан ч 2012 оны хавраас НАЧА болон ДЦС-ын мэргэжилтний дэмжлэггүйгээр хэмжилтийг хийж чадахгүй болсон.

Хийсэлтийн хэмжээ

Одоо ашиглаж байгаа үнсэн сан (ДЦС II-ын зүүн талын үнсэн сан, ДЦС III-ын 5-р

■ “ДЦС-ын үнсэн сангаас хийсэх АББ-ын инвентор” гэдэг нь “АББ-ын эх үүсвэрийн инвентор” гэдэг нь агаарын бохирдлын мэргэжилтнүүдийн дунд яригдаж хөвшсөнээр “АББ-ын ялгарлын хэмжээний данс бүртгэл”-ийг илэрхийлсэн хэллэг юм. Үүнд ДЦС-ын үнсэн сангаас хийсдэг зүйл, өөрөөр хэлбэл тоосонцор (PM зэрэг) –ыг хамруулдаг. Тоосонцорыг ширхэгийн хэмжээгээр нь ангилдаг боловч тооцоолоходоо эхлээд нийт ялгарлын хэмжээг гаргаад, дараа нь ширхэгийн диаметр нь 10 микроноос бага PM10-ын хэмжээг ойролцоогоор тооцдог. УХЗ болон гэрийн зууханд нүүрс шатаахад тоосонцор зэрэг янз бүрийн АББ ялгарч, энэ нь УБ хотын хэмжээнд томоохон асуудал болж буйг та бүхэн мэдэх билээ. Нүүрс шатаахад их хэцүү хэмжээний шатсан үнс үлддэг ба энэ үнс нь хүчтэй салхинд хийсч буцжигнан, тоосонцороо үлдэлтэй агаарын бохирдлыг бий болгодог.

Мөн “ДЦС-ын үнсэн сангаас хийсэх АББ-ын эх үүсвэрийн инвенторын ажиллагаа” гэдэг нь үнсэн сангаас хийсдэг АББ-ын хэмжээг тооцоолох ажлыг хэлнэ. УБ хотын агаарын бохирдолд авах арга хэмжээнд үнс хийсэлтийг хир хэмжээнд багасгах шаардлагатай байгаа, ямар аргаар хир зэрэг багасгах, түүнийг хэрэгжүүлэхэд хичнээн хэмжээний тэтгэмж, хөрөнгө мөнгө гаргах ёстой эргийг судлахын тулд юуны өмнө хийсэлтийн хэмжээг судлах нь чухал юм.



ДЦС-ын үнсэн сан (2010 оны 6 сарын 3 өдөр 14:00 цаг)

Үнсэн сангийн гадаргын өнгөн хэсэгт салхинд элэгдсэн хэсэг их байгаагаас харахад үнс ихээр хийсдэг болох нь тодорхой байдаг.



Салхинд хийсэх үнсний хэмжээг тооцоолох янз бүрийн арга байдаг боловч УБ хотын хувьд хийсэлтийн хэмжээ ихтэй учраас оновчтой тооцоолох арга байдаггүй тул оронд нь УБ хотын нөхцөлд тохирсон хэмжилтийн болон тооцооллын аргыг судалж олсон.

үнсэн сан, ДЦС IV-ийн 5-р үнсэн сан) нь хангалттай чийгтэй байгаа мөн хөрсөөр хучих, мод тарих зэрэг ажил амжилттай хийгдсэн хэсэгт үнсний өнгөн хэсэг далдлагдсан тул үнс бараг хийсдөггүй. Ийм газраас үнс хийсэхгүй гэж үзээд, хийсэлтийн хэмжээг тооцоолсон ба энэ тооцооллын аргын талаар тайланд тодорхой бичсэн байгаа тул энд товчлон орхиё.

Гурван ДЦС-ын хэмжээнд нийт 2.560 тонн PM-10 хийсэн байна. Гэвч элэгдлийн зузаан нь мм-ээс доошх нэгжээр хэмжих боломжгүй тул хэмжилтийн тоо нь 1-2 оронтой тоо байдаг. Энэ хийсэлтийн хэмжээ нь гэрийн зуух, ханан пийшингийн ялгарлын нийт хэмжээ (жилд 3.654 тонн), УХЗ-ны ялгарлын хэмжээ (жилд 2.812 тонн) –нээс хол зөрүүгүй байна. Өөрөөр хэлбэл, үнсэн сан нь УБ хотын хувьд (PM10-ыг анзааралгүй оршихын аргагүй) агаарын бохирдлын томоохон эх үүсвэр гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Гэвч үнсэн сангийн хувьд голчлон 3-6 сарын хооронд хийсэлт их байдаг бол халаалтаас үүдэлтэй АББ-ын ялгарал нь голчлон өвлийн улиралд байдаг. Иймд 3-6 сарын агаарын орчин дахь PM10-ын агууламжид үнсэн сангийн нөлөөлөл их байдаг гэж үзэж байна.

Цаашдын үйл ажиллагаа

ДЦС III-ын 4-р үнсэн сан болон ДЦС II-ын баруун талын үнсэн санд хэмжилтийг үргэлжлүүлэн хийж, өгөгдлийг ашиглан ялгарлын хэмжээний мэдээллийг шинэчилж байх болно.

Япон мэргэжилтэн нь Монголд байнга байдаггүй мөн төслийн оффис (Хангарьд ордон) нь үнсэн сангаас хол байдаг тул япон мэргэжилтэн ч НАЧА ч үнсэн сангийн байдлыг байнга ажиглаж хянаж боломжгүй байдаг. УБ хотын АБ-д дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэхэд үнс хийсэлтийн байдлыг НАЧА-д мэдээлэх, алсаас ажиглалт хийх боломжтой хяналтын камерыг суурилуулах зэргээр холбогдох мэдээлэл цуглуулахад хамтран ажиллахыг хүсч байна.

Бага төсөв, хялбар хэмжилт, тооцооллын аргаар хийсэлтийн хэмжээг тооцоолж байгаа учраас тус төслийг дууссан ч хэмжилтийг цаашид үргэлжлүүлэн хийхэд бэрхшээл байхгүй тул энэ ажлыг үргэлжлүүлэн хийнэ гэж найдаж байна.

Үнс хийсэлтэнд авах арга хэмжээ, түүний цаашдын хэрэгцээ шаардлага

2010-2011 онд ДЦС III-ын 4-р үнсэн сан, ДЦС IV-ийн үнсэн санг хөрсөөр хучиж, мод тарих ажил хийгдэж байгааг үр дүнд үнсэн сангаас хийсэх үнсний хэмжээ багасах байна. Гэвч моджуулахад бэрхшээлтэй орчин тул нарны эрчим хүч үүсгэвэр байрлуулах зэргээр өөр ашиглалтын аргыг олох нь илүү зохимжтой болов уу.

Одоо ашиглагдаж буй үнсэн сан хэдэн жилийн дараа дүүрэхэд түүнийг бүрэн хатаахын тулд нэг хэсэгтээ хөрсөөр хучих боломжгүй байдаг тул үнс их хэмжээгээр хийсэх магадлалтай. “Эрчим хүчний тухай” хуулийн 24.3.5 болон 25.1.11 заалт, Цэвэр агаар сангийн зарчимд үндэслэн, үнсэн санг дүүрэхээс өмнө салхинаас хамгаалах хаалт хийх зэрэг авах арга хэмжээний талаарх судалгааг хийж, оновчтой арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж найдаж байна.

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатар дүүрэг 3, Улаанбаатар
Утас: 976-11-325939, 312393 Факс: 976-11-310845
<http://www.jica.go.jp/mongolia/index.htm>

Төслийн оффис

Хангарьд ордон, 4 давхар, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-9, Улаанбаатар (Нийслэлийн Агаарын чанарын алба (НАЧА))
Утас: 976-11-318551 Факс: 976-11-318551

Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл

Мэдээллийн тойм Vol. 5 (2012 он 6 сар)

Агаар бохирдуулагч бодисын эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалыг ашиглан агаар орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх

ЖАЙКА-ын техник хамтын ажиллагааны төслийн товч агуулга

ЖАЙКА-ын техник хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл” нь 2010 оны 3 сараас эхэлсэн бөгөөд 2013 оны 3 сар хүртэл хэрэгжих төлөвлөгөөтэй байна.

Агаарын бохирдолд авах арга хэмжээг хэрэгжүүлэх төр захиргааны бүтэц, тогтолцоо хангалттай бүрэлдээгүй байгаа нөхцөл байдлыг харгалзан тус төслийн хүрээнд Нийслэлийн болон холбогдох салбарын байгууллагын боловсон хүчнийг бэлтгэж, агаарын бохирдолд авах арга хэмжээний чадавхийг бэхжүүлэхийг зорьж байгаа юм. Байгууллага тус бүрийн удирдлагын менежментийн чадавхийг бэхжүүлэн, холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулснаар агаарын бохирдолд авах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, цаашид бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг бодитойгоор бууруулах боломжтой болох юм.

Төслийн үйл ажиллагаа

Тус төсөл нь дараах таван үр дүнд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Гарах үр дүн 1	Агаар бохирдуулагч бодисын эх үүсвэрийн инвенторыг боловсруулан, тархалтын загварчлалаар агаар орчинд нөлөөлөх байдлыг үнэлгээ хийнэ.
Гарах үр дүн 2	ДЦС болон УХЗ-ны утааны хийн хэмжилтийн технологийн үр чадавхийг эзэмшүүлнэ. (Зарим нэг гэрийн зууханд утааны хийн хэмжилт хийх)
Гарах үр дүн 3	Бохирдлын эх үүсвэрт хяналт тавих төр захиргааны тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлнэ.
Гарах үр дүн 4	ДЦС болон УХЗ-нд эрчим хүч, дулаан хэмнэлтийн оношилгоо хийж, агаарын бохирдолд авах арга хэмжээний саналыг өргөн барина.
Гарах үр дүн 5	Бусад хандивлагч байгууллага болон Монгол талаас хэрэгжүүлж байгаа агаарын бохирдолд авах арга хэмжээний хөтөлбөрт хувь нэмэр оруулана.

Эдгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлснээр хамтрагч талын холбогдох байгууллагын агаар орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх чадавхи, бохирдуулах бодисын ялгаруулалт болон түүнд авах арга хэмжээний хяналт, удирдлагын чадавхи, харилцааны болон менежментийн чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Эдгээрийн дотроос эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын (Гарах үр дүн-1) талаар танилцуулж байна.

Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын үйл ажиллагаа

Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварын модельтой холбоотой үйл ажиллагаа




Ажил хэргийн хуралдаан

Тархалтын загвар модель боловсруулалт

Баруун талын зурагаар үзүүлсэнчлэн тархалтын загвар модель гэдэг нь эх үүсвэрийн инвентор болон цаг агаарын өгөгдлийг ашиглан тооцоолсон дүнтэй суурин харуулын дүнг харьцуулан авч үзэж байж моделийг боловсруулдаг. Энэ моделийг тооцоолоос үр дүнтэй агаарын бохирдолд авах арга хэмжээг судалж үзэх хэрэгсэл болгодог.

Гарах үр дүн-1-ийн хувьд дээрх байдлаар цуглуулж-эмхтгэсэн суурь оны эх үүсвэрийн инвентор, цаг агаарын өгөгдөл, агаар орчны өгөгдөл зэргийг ашигласан



тархалтын загвар моделийг боловсруулан гаргасан.


Ялгарлын хэмжээг тооцоолсон дүн болон тархалтын загварчлалын дүн

SO₂ болон PM₁₀-г эх үүсвэр тус бүрийн ялгарлын хэмжээ

Суурь оны суурин эх үүсвэрийн инвентор, хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор, бусад талбайн эх үүсвэрийн инвенторыг эмхлэн нэгтгэсэн дүн гарган, SO₂ болон PM₁₀-н эх үүсвэр тус бүрийн ялгарлын тархалт болон агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээний тархалтыг тооцоолсон. Түүний үр дүнд, SO₂-н хувьд ДЦС болон гэр хорооллын дүүргийн ялгарлын хэмжээ ихэссэн байна. PM₁₀ хувьд ДЦС, газрын гадаргууны сул шороо бужигналтын хэмжээ ихэссэн байна. Улмаар PM₁₀ нь жижиг ширхэгтэй чийглэг тоосонцорын нэгдлүүдээс бүрддэг тул хэмжээ, химийн найрлага, төлөв чанарууд нь ихээхэн ялгаатай байдаг. Байгалийн эх үүсвэр (ургамлын тоосонцор, далайн давсны тоосонцор, газрын гадаргууны тоосонцор, галт уулын лаав гэх мэт), хүний үйлдлээс үүсэх тортогжилт, хийсэмтгий үнс, төмрийн исэл зэргээс тоос тоосонцорууд ялгарч байдаг.


Суурь оны SO₂ болон PM₁₀-ялгарлын хэмжээ (т/ж)

Эх үүсвэр	SO ₂	PM ₁₀
ДЦС	13,282.29	11,551.03
УХЗ	1,369.82	2,811.86
БОУХЗ	313.09	130.79
Гэр	4,675.14	3,654.39
Гол зам	203.23	199.64
Нарийн зам	66.55	65.38
Тоос бужигналт		9,266.10
Үнсэн сан		2,560.36
Нийт	19,910.13	30,239.55



SO₂ болон PM₁₀-н агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээний тархалт (Суурь оны)

байна. Ийм учраас өнгөрөлт өндөртэй болж байгаа гэж үзэж байна. Суурин харуулаар хэмжигдэж байгаа SO₂-н агууламжийг тооцоолсон утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулж үзэхэд бараг адилхан утга гарч байгаа бөгөөд энэ нь тархалтын загварын модель үнэн зөв болсон гэж дүгнэж болно. Гэвч PM₁₀-н агууламжийн хувьд тархалтын загвараар тооцоологдох утга нь бодит хэмжилтийн утганы талд нь байгаа тул энэ агууламжийн зөрүүний шалтгааныг олж тогтоох шаардлагатай байна.



SO₂ болон PM₁₀-тооцоолсон агууламжийн тархалт (2010 оны 11 сараас 2011 оны 2 сар) Нэгж : $\mu\text{g}/\text{m}^3$

Хэтийн үйл ажиллагаа

Цаашид эх үүсвэрийн инвенторыг тогтмол шинэчилж чаддаг болгохын тулд суурь оныг өөрчлөх, утааны хийний хэмжилтийн үр дүн, УХЗ-ны газар дээрх судалгаа болон судлийн үеийн статистикийн тоо баримтыг ашиглаж инвентор, тархалтын загвар моделийг дахин боловсруулах ажлыг 2012 оны 9 сар хүртэл Монгол тал голлож хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Мөн боловсруулсан моделийг ашиглан агаарын бохирдолд авах төрөл бүрийн арга хэмжээнд хамааралтай агаар орчны агууламжийг тооцоолж, байгаль орчны стандартыг хангахад нэн шаардлагатай арга хэмжээнийг нэгтгэж гаргах төлөвлөгөөтэй байна.

Төсөл хэрэгжиж дууссанаас хойш НАЧА, ЦЭОШГ (Цаг уур орчны шинжилгээний газар), болон холбогдох байгууллагууд нь өгөгдөл мэдээллийн шинэчлэлийг хийж чаддаг байх бүтэц бүрэлдүүнтэй болгохыг зорьж байгаа болно.

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-3 Бодь цамхаг 7 дугаар давхар
Утас: 976-11-325939, 312393 Факс: 976-11-310845
<http://www.jica.go.jp/mongolia/index.htm>

Төслийн оффис

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-9 Хангарьд ордон 4-р давхар НАЧА (Нийслэлийн Агаарын Чанарын Алба)
ТЕЛ: 976-11-318551 FAX: 976-11-318551

Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл

Мэдээллийн тойм Vol. 6 (2012 он 6 сар)

Агаарын бохирдолд авах арга хэмжээ-Эрчим хүч дулаан хэмнэлтийн оношилгоо

ЖАЙКА-ын техник хамтын ажиллагааны төслийн товч агуулга

ЖАЙКА-ын техник хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй "Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл" нь 2010 оны 3 сараас эхэлсэн бөгөөд 2013 оны 3 сар хүртэл хэрэгжих төлөвлөгөөтэй байна.

Агаарын бохирдолд авах арга хэмжээг хэрэгжүүлэх төр захиргааны бүтэц, тогтолцоо хангалттай бүрэлдээгүй байгаа нөхцөл байдлыг харгалзан тус төслийн хүрээнд Нийслэлийн болон холбогдох салбарын байгууллагын боловсон хүчнийг бэлтгэж, агаарын бохирдолд авах арга хэмжээний чадавхийг бэхжүүлэхийг зорьж байгаа юм. Байгууллага тус бүрийн удирдлагын менежментийн чадавхийг бэхжүүлэн, холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулснаар агаарын бохирдолд авах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, цаашид бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг бодитойгоор бууруулах боломжтой болох юм.

Төслийн үйл ажиллагаа

Тус төсөл нь дараах таван үр дүнд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Гарах үр дүн 1	Агаар бохирдуулагч бодисын эх үүсвэрийн инвенторыг боловсруулан, тархалтын загварчлалаар агаар орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийнэ.
Гарах үр дүн 2	ДЦС болон УХЗ-ны утааны хийн хэмжилтийн технологийн үр чадавхийг эзэмшүүлнэ. (Зарим нэг гэрийн зууханд утааны хийн хэмжилт хийх)
Гарах үр дүн 3	Бохирдлын эх үүсвэрт хяналт тавих төр захиргааны тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлнэ.
Гарах үр дүн 4	ДЦС болон УХЗ-нд эрчим хүч, дулаан хэмнэлтийн оношилгоо хийж, агаарын бохирдолд авах арга хэмжээний саналыг өргөн барина.
Гарах үр дүн 5	Бусад хандивлагч байгууллага болон Монгол талаас хэрэгжүүлж байгаа агаарын бохирдолд авах арга хэмжээний хөтөлбөрт хувь нэмэж оруулна.

Эдгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэнээр хамтрагч талын холбогдох байгууллагын агаар орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх чадавхи, бохирдуулах бодисын ялгаруулалт болон түүнд авах арга хэмжээний хяналт, удирдлагын чадавхи, харилцааны болон менежментийн чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Эдгээрийн дотроос Агаарын бохирдолд авах арга хэмжээ болон эрчим хүч хэмнэлт оношилгооны (Гарах үр дүн-4) тухай энэ удаа танилцуулж байна.

Агаарын бохирдолд арга хэмжээ авахад зориулсан зуухны бүтээмжийн хэмжилт

Одоо Улаанбаатар хотод асуудал болоод байгаа ДЦС-н зуух болон УХЗ (Усан халаалттай зуух)-аас ялгарах тоосыг бууруулах явдал бөгөөд ерөнхийд нь 2 аргаар бууруулж болно. Нэгдүгээрт тоосыг шүүх төхөөрөмж суурилуулах арга хэмжээ юм. Жиншлэлбэл ДЦС-4 дээр шахилгаан шүүлтүүр гэдэг тоос шүүлтүүн АУК 90% аас дээш тоноглол суурилан байх бөгөөд хэд хэдэн төрлийн УХЗ-нд

циклон шүүлтүүрийг суурилуулсан байна. Шинээр тоноглол суурилуулах арга хэмжээ нь үр дүнд өндөртэй гэж харгалдах боловч нэлээн өндөр өртөг бүхий хөрөнгө оруулалт шаардлага болох ба зуухнаас шалтгаалан нэмэлтээр уг тоноглолыг суурилуулах боломжгүй нөхцөл ч үүснэ.


Өөр нэг арга нь зуухны бүтээмжийг сайжруулан нүүрсний зарцуулалтыг бууруулж, түүний үр дүнд янданаас ялгарах тоосны хэмжээг бууруулах явдал юм. Энэ арга хэмжээнд галалгааны өөрчлөлт болон харьцангуй багахан сайжруулалтаар үр дүн гарах тохиолдол ч байна.

Төслөөр зуухны бүтээмжинд хэмжилт хийж тэр үр дүнд үндэслэн зуухны бүтээмжийг сайжруулах судалгааг хийж байна. 2010 оны өвөл НАЧА, УХЗ-ны үйл ажиллагаа эрхлэгч, үйлвэрлэгч болон үйлдвэрүүдийн холбогдох хүмүүсийг оролцуулан УХЗ-ны газарт зуухны бүтээмжийн хэмжилтийн дадлага сургалт явуулсан.

Зуухны бүтээмжийн хэмжилт хийхийн тулд янз бүрийн параметрын хэмжилт хийх шаардлагатай байдаг учраас төслөөр худалдаж авсан утааны хийний шинжилгээний хэмжүүр, хэт авианы зарцуулалт хэмжигч, термомпар (дулаан мэдрэгч утас) зэрэг хэмжилтийн багажийг ашиглаж хэмжилт хийсэн. Мөн өгсөн дулаан ба шатаж үлдсэн үнс шаарагийн дулааны хэмжээг тусад нь шинжлэн, эцэст нь зуух руу оруулсан нийт дулааны хэмжээгээс хэр зэрэг дулаан системийн усны түгээлтэнд зарцуулагдаж байгаа тооцоохоос гадна ямархуу дамжилгаар эрчим хүч энерги алдагдаж алдагдаж байгааг нягталж үзсэн.



Зуухны бүтээмжийн хэмжилтийн байдал



Зуухны бүтээмжийн хэмжилтийн үзүүлэлт

Үүний үр дүнд энэ УХЗ-ны бүтээмж 78.2%, утааны хийтэй алдагдах дулаан нь маш өндөр 12% дулаан алдагдаж байсан. Энэ шалтгаан нь агаар халагч гэдэг утааны хийг дахин эргэлдүүлж тоноглолыг суурилуулаагүй явдал, агаарын харьцааны тохиргоо хийгдээгүй байгаагай холбоотойгоос гадна галын хотлын даралт (сийрэг)-ыг хэмжигдэггүй, мөн агаарын нэвчилтэй байгаа зэргээс

шалгааж байна гэж үзсэн. Өөр нэг жишээнд утаанд алдагдах дулаан нь 40-50%-тай байх бөгөөд зуухны бүтээмжийг маш их доройтуулсан байлаа. Нөгөөтгэйгүүр утааны сувагийн засвар үйлчилгээ хангалтгүй байгаа УХЗ-нд утааны сувагнаас гадна агаар нэвчин орж улмаар утааны хийний температур буурж хангалттай сийрэг (хасах даралт) үүсгэлгүй галын хотлын утаарын хий зуухны амаар борж өрөө тасалгааны орчныг ноцтойгоор бохирдуулж байгаа жишээ олон байлаа. Эдгээр асуудлаас хуучин байгаа УХЗ-уудад ялангуяа галын хотлын сийрэгжилтийн хяналт чухал болж байгааг ойлгосон.

Дулааны балансын нэгтгэл				
Гарчиг	Нэгж	Утга	Хувь	
Орох дулаан	Нүүрсний дулаан	kcal/h	750,240	100.0
	Нийт	kcal/h	750,240	100.0
Гарах дулаан	Тэжээлийн усны дулааны хэмжээ	kcal/h	586,474	78.2
	Цацрагийн дулаан алдалт	kcal/h	46,848	6.2
	Үнсний бодит дулаан	kcal/h	4,694	0.6
	Үнсэн доторх бүтэн шатаагүй нүүрсгөрөгч	kcal/h	22,785	3.0
	Утааны хийн алдалт	kcal/h	89,602	11.9
	Тодорхой бус дулаан	kcal/h	-163	0.0
Зуухны АУК	Нийт	kcal/h	750,240	100.0
	%			78.2

Агаарын бохирдолд авах арга хэмжээнд зориулсан эрчим хүч дулаан хэмнэлтийн оношилгоо

Зуух түүний бүтээмжийн сайжиралттай адил ДЦС-аас түгээж байгаа уур болон цахилгааныг илүү үр ашигтай ашигласнаас ДЦС-аас түгээх эрчим хүч хэмнэгдэх энэ нь ДЦС-ын нүүрсний хэрэглээний хэмжээ болон тоосны ялгаралын хэмжээ буурахад нөлөөлнө. Томоохон хэрэглэгч болох үйлдвэрүүдийг голлон иймэрхүү эрчим хүч дулаан хэмнэлтийн оношилгоо явуулж хэмнэлтийн чадамжийг судалж үзсэн. Мөн эрчим хүч дулаан хэмнэлтийн арга хэмжээнд цахилгааны төлбөр гэсэн эрчим хүчний зардал хэмнэгдэх ач тус байгаа учраас үйл ажиллагаа эрхлэгч нар хүлээн авч болохуйц гэсэн давуу ч бас байлаа.

Хэд хэдэн үйлдвэрүүдэд анхан шатны оношилгоо хийж, хамруулах үйлдвэрүүдийг сонгосны дараа нарийвчилсан эрчим хүч дулаан хэмнэлтийн судалгаа хийсэн. Эрчим хүчний оношилгоонд термокамер, термомпар гэсэн багажийг ашиглаж оношилгоо хийсэн.

Термокамераар оношилж үзэхэд уурын шугамын хавхлага болон фланцын хэсгүүдэд дулаалгагүй, хоолойнуудад ч мөн дулаалга хийгдээгүй хэсэг байгаа нь эдгээр хэсгээс их хэмжээний дулаан алдагдаж байгааг ойлгосон. Жишээ нь хавхлаганы тухайд дулаалгын цамцны хийхэд ч амархан дулаалснаар үр дүнд өндөртэй учраас энэ аргыг санал болгосон.



Эрчим хүч дулаан хэмнэлтийн оношилгооны байдал


Мөн энэ үйлдвэр ДЦС-аас орж ирж байгаа уурыг хүлээн авч байгаа боловч үйлдвэр нь алслагдсан газар байрлах тул замдаа их хэмжээний ус үүсэж тэр уурын ус нь хоолойн доод хэсэгтээ хуримтлагдаж байгаагаас уурын дотор их хэмжээний ус агуулагдаж очиж байх бөгөөд уур авах хоолойн хамгийн сүүлийн өргөгдөж боссон хэсэгт дараах асуудал үүсэж байгаа гэж үзсэн.

- 1) Уурын хоолой доторх урсгалын эзлэхүүн зарим хэсэгтээ багасгах учраас хоолойны даралт алдалт ихэсгэж, улмаар уурын даралт буурахтай зэрэгцээ даралтын хэлбэлзэл үүсдэг.
- 2) Уранд доторх уурнаас илүү дулаан агуулалт багатай ус ихээр агуулагдах учир бодитоор авч байгаа дулааны хэмжээгээс илүү их хэмжээтэй тооцогдож байгаа юм.


Өөрөөр хэлбэл энэ үйлдвэр уурын хангалт гэсэн үйлчилгээ авч байгаа талаасаа муу чанарын үйлчилгээ авчихаад илүү их хэмжээтэй хэрэглэсэн болж төлбөр төлж байна гэсэн үг юм. Үүнд авах арга хэмжээ болгож уурын хоолойн боссон хэсэгт уурын ус зайлуулагч суурилуулах шаардлагатай юм.



Шугамын хавхлага



Термокамерын зураг



Уурын усны байдал

Эдгээр хэмжилт-оношилгоонд тулгуурлан агаарын бохирдолд авах арга хэмжээний саналын зөвлөмж гаргах төлөвлөгөөтэй байна.

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-3 Боль цамхаг 7 дугаар давхар
Утас: 976-11-325939, 312393 Факс: 976-11-310845
<http://www.jica.go.jp/mongolia/index.htm>

Төслийн оффис

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-9 Хангарьд ордон 4-р давхар НАЧА (Нийслэлийн Агаарын Чанарын Алба)
TEL: 976-11-318551 FAX: 976-11-318551

Хавсралт2.5-6 Нэгдсэн семинарын илтгэлийн материал



УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫН ХЯНАЛТЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



ЖАЙКА-гийн техник хамтын ажиллагааны төсөл 2009-2013 оны хооронд Нийслэлийн Агаарын чанарын албан дээр "Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх" чиглэлээр хэрэгжиж дуусч байгаатай холбогдуулан зохион байгуулагдаж байгаа нэгдсэн семинарт

ЭРХЭМ ХҮНДЭТ ТАНЫГ ХҮРЭЛЦЭН ИРЭХИЙГ УРЬЖ БАЙНА.

ОГНОО: 2013 оны 01 сарын 31-ны өдөр (ПҮ) 13:30~16:45

БАЙРЛАЛ: Монгол-Япон төвийн 1 давхарын хурлын зааланд
(Семинарын үйл ажиллагаа Монгол болон Япон хэл дээр явагдана)

СЕМИНАРЫН ХӨТӨЛБӨР

Нээлтийн мэндчилгээ Хотын орлогч дарга, ЖАЙКА төлөөлөгчийн газар	13:30-13:40
Үр дүнгийн илтгэл <u>Утааны хэмжилтийн тухай илтгэл</u>	13:40-14:00
ОЧИ мэргэжилтэн, Г. Даваажаргал /НАЧА мэргэжилтэн/ <u>Зуух Бүртгэл Хяналтын Тогтолцоо ЗБХТ тухай илтгэл</u>	14:00-14:20
Төслийн ахлах Фукаяма, Х.Галымбек /НАЧА мэргэжилтэн / <i>Асуулт-Хариулт</i>	14:20-14:30
<u>Завсарлага</u>	14:30-14:50
<u>Эх үүсвэрийн инвентор-тархалтын загварчлалын тухай илтгэл</u> Табата мэргэжилтэн, С.Энхмаа /ЦУОШГ мэргэжилтэн /	14:50-15:10
<u>Агаарын бохирдолд авах арга хэмжээ болон</u> (Накажима, Ч.Сэдэд/НАЧА/)	15:10-15:30
<u>Эрчим хүчний хэмнэлтийн тухай илтгэл</u> (Хигаки мэргэжилтэн, Г.Цолмон /НАЧА/)	15:30-15:50
<i>Асуулт-Хариулт</i>	15:50-16:00
<u>Агаарын бохирдолд авах арга хэмжээний зөвлөмж</u> Ч.Батсайхан /НАЧА дарга/	16:00-16:10
<u>Монгол талын бүтцийг бүрдүүлэхтэй холбоотой зөвлөмж</u> Төслийн ахлах Фукаяма	16:10-16:20
<i>Асуулт-Хариулт</i>	16:20-16:30
<u>Нэгдсэн дүгнэлт</u> Ямада зөвлөх мэргэжилтэн	16:30-16:45
Дурсгалын зураг авах	

УТААНЫ ХИЙН ХЭМЖИЛТИЙН СТАНДАРТ АРГАЧЛАЛУУД






**ЖАЙКА-н мэргэжилтэн,
Утааны хийн хэмжилтийн баг**

1

Утааны хийн хэмжилтийн объект 1 ДЦС




2

Утааны хийн хэмжилтийн объект 2 УХЗ





3

Утааны хийн хэмжилтийн объект 3 Гэрийн зуух




4



УТААНЫ ХИЙН ХЭМЖИЛТИЙН АГУУЛГА БОЛОН АРГАЧЛАЛ (УТААНЫ ХИЙ)

Хийн үзүүлэлтүүд	Тохируулсан норм стандарт	Агууламжийн дээд хязгаар
SO ₂	JIS B 7981 (Хэт ягаан туяаны шингээлтийн аргачлал)	0 ~ 1000 ppm
NOx	JIS B 7982 (Фотохимийн шингээлтийн аргачлал)	0 ~ 1000 ppm
CO	JIS B 7987 (Хэт ягаан туяаны шингээлтийн аргачлал)	0 ~ 5000 ppm (Бага агууламжтай) 0 ~ 5 % (Өндөр агууламжтай)
O ₂	JIS B 7983 (Гальваникийн аргачлал)	0 ~ 25 %
CO ₂	JIS B 7986 (Хэт ягаан туяаны шингээлтийн аргачлал)	0 ~ 20 %

Хэмжилтийн аргачлалын онцлог

Хэд хэдэн төрлийн утааны хийн үзүүлэлтүүдийг нэгэн зэрэг тогтмол хугацаанд хэмжилт хийх боломжтой газ анализатор (**оптик сенсортой**)-г ашигладаг. (O₂-н хувьд химийн сенсор байж болно).

Хэдэн секундын хугацаанд 1 өгөгдөл авдаг бөгөөд урт хугацааны турш зогсолтгүй тогтмол хэмжилт хийх боломжтой.

Хэмжилтийн өгөгдлүүдийг мэдээлэл багцлагчид хадгалж, дараагаар нь компьютер ашиглан боловсруулалт хийдэг. (Химийн сенсортой газ анализаторыг тогтмол хэмжилтийн горимд ажиллуулахаас зайлхийх хэрэгтэй).

7

УТААНЫ ХИЙН ХЭМЖИЛТИЙН АГУУЛГА БОЛОН АРГАЧЛАЛ (ТООС)

Агуулга	Тоос (Температур, даралт, чийг, хурд)
Стандарт	JIS Z 8808

Утааны хийнд агуулагдах тоосыг **сика** материалзаар хийгдсэн фильтриг цуглуулаж, соруулсан хийн эзэлхүүн болон дээжний жингээр тоосны агууламжийг тодорхойлж гаргадаг. Фильтриг нийт тоосыг шүүнэ. (Харин конденсацнаас үүссэн хатуу бүтэцтэй тоос хамаарахгүй)

Хэмжилтийн аргачлал түрүүн онцлог 1

<Дүгнэж, дараалал>
Утааны сувагны мөндлөн огтлолд тогтоосон аргачлалын дагуу хэмжилтийн цэгийг сонгоно.

Утааны хийн температур, даралт (хурд), чийг, хийн найрлагуудыг хэмжинэ. (Бэлтгэл хэмжилт)

Тоосны дээж авчгч пробыг утааны суваг дахь хэмжилтийн цэгт байрлуулна. Хэмжилтийн цэг бүрт утааны хийн урсгал хуртай ижил хурдаар утааны хийг соруулдаг. (**Ижил хурдаар соруулах**).

Хэмжилтийн аргачлал түрүүн онцлог 2

- Хагас механикжсан багаж ашиглан тоосны дээж авах арга (Эзгийг хэлбэр)
- Бэлтгэл хэмжилтийн үр дүнд тулгуурлан тоосны дээж авах нөхцөлийг компьютерт боловсруулж, багаж тохоромжийг суурилуулснаар хэмжилт эхлэнэ. **Ижил хурдны тохиргоог гаргаар тохорлуулах** шаардлагатай.
- Автомат ажиллагаатай багаж ашиглан тоосны дээж авах (Динамик даралтын балансд хэлбэр)

Энэ тохиолдолд бэлтгэл хэмжилт хийх шаардлагагүй. (Чийгийг тусд нь хэмэжг). Утааны хийн төвийн өөрчлөлтийг тухайн агшин бүрт багаж өөрөө мэдэж, тооцож, автоматаар ижил хурдны тохиргоог явуулдаг. Хагас механикжсан багажтай харьцуулахад хурдан үйлдэлтэй бөгөөд онцор нарийвчлалтай үр дүн гаргадаг.




8

Хэмжилтийн зааварчилгаа, гарын авлагууд



9

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА




10

“Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”

Утааны хийн хэмжилтийн аргазүй ба хэмжилтийн үр дүн

Г.Даваажаргал
Нийслэлийн Агаарын чанарын албаны мэргэжилтэн



1


Агуулга

- Төсөл хэрэгжсэн байдал
- Утааны хийн хэмжилтийн аргазүйг эзэмшүүлэх үйл ажиллагаа, холбогдох үр дүн
- Төслийн хүрээнд хийгдсэн хэмжилтийн үр дүн
- Дүгнэлт

2

Төсөл хэрэгжилтийн байдал

Нийслэлийн Агаарын чанарын алба нь 2009 онд алба өргөжсөн ба тухайн үед хэмжилтийн багаж тоног төхөөрөмжийн тал дээр хомс байсан. 2009 оны уг төслийн суурь судалгаа явагдаж албан ёсоор 2010 онд эхэлсэн юм. “ЖАЙКА” байгууллагын хэрэгжүүлсэн төсөл эхлэхээс өмнө манай алба нь хаягдал утааны хийн хэмжилтийг дан ганц ХБНГУ-д үйлдвэрлэсэн TESTO-350XL багаж ашиглаж утааны хийн найрлага дахь CO-Угаарын хий, NOx-Азотын ислүүд, SO2-хүүхэрлэг хий зэрэг химийн найрлагыг дангаар нь хэмждэг байсан. Хаягдал утааны хийн бүхий л хэмжилтэнд уг багаж ашигладаг байсан.



3

2010 оноос “ЖАЙКА” байгууллагын буцалтгүй тусламжаар “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх” төсөл албан ёсоор эхэлж үндсэн 6 чиглэлээр хэрэгжих болсон. Эдгээрийн дундаас Утааны хийн хэмжилтийн арга зүйг эзэмшүүлэх чиглэлд миний бие оролцож ажилласан. Утааны хийн хэмжилтийн чиглэлээр хаягдал утааны хийн хэмжилтийн сургалтыг 2010 онд Япон улсад зохион байгуулсан юм. Уг сургалтад дараахь хүмүүс хамрагдсан.

Сургалтад оролцогчид	Харьяалал
Г. Даваажаргал	НАЧА
Д. Даваадорж	НАЧА
Ж. Баярмагнай	УАЧМА
Ц. Алтангэрэл	ДЦС-4
Б. Мөнхтулга	ДЦС-4
С. Энхтүвшин	ДЦС-2
Н. Эрдэнэбилэг	БОЦУТЛ
Н. Ганзориг	ДЦС-3

4

Утааны хийн хэмжилтийн аргазүйг эзэмшүүлэх үйл ажиллагаа, холбогдох үр дүн (1)

- Японд сургалтад оролцогчид хаягдал утааны хийн хэмжилтийн үндсэн аргачлал болон хэмжилтийн арга барилд суралцаж мэргэжлийн сертификаттай болсон. Сургалтын дараа төслийн хүрээнд ДЦС-ууд болон УХЗ-ууд дээр хаягдал утааны хийн хэмжилтийг удаа дараа хийж боловсон хүчний ур чадварыг дээшлүүлж дадлаажуулж байсан.
- Төсөл хэрэгжсэн 3 жилийн хугацаанд утааны хийн хэмжилтийн аргазүйгэй холбогдуулсан мэргэжлийн сургалт семинарыг төслийн мэргэжилтний зүгээс олноор зохион байгуулж, хэмжилтийн талбар дээр сурсан мэдлэгийг бататгах, туршлага хуримтлуулж дадлаажуулсан.
- Утааны хийн хэмжилтийн техникийн гарын авлага, хэмжилтийн стандарт зааварчилгаа зэргийг боловруулан гаргасан нь холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийн ажилд нэмэр болохуйц үр дүнтэй ажил болсон гэж үзэж байна.



5

Утааны хийн хэмжилтийн аргазүйг эзэмшүүлэх үйл ажиллагаа, холбогдох үр дүн (2)

Төсөл хэрэгжихээс өмнө: Testo 350XL- CO, NOx, SO2 (зөвхөн утааны хийн найрлага)

Төсөл хэрэгжсэнээс хойш: Газ анализатор, тоосны дээж соруулагч багаж зэрэг хэмжилтийн багаж, төхөөрөмж (хагас механик, автомат-тасралтгүй хэмжилт)



6

Хэмжилтийн баг

№	Хэмжилтэд оролцогсод	Харьяалал	Оролцооны чиглэл
Төрийн байгууллага	Тошихару Очи	Сүүрийкейаку	Сургагч багш
	Тадаёши Үсүй		
	Сакура		
	Нобухиро Хонда		
Хувийн хэргийн байгууллага	Хишигжаргал	ЛІСА төслийн орчуулагч	Орчуулагч
	Г. Даваажаргал	НАЧА	Суралцагч
	М. Отгонбаяр	НАЧА	
	Ж.Баярмагнай	УАЧМА	
	Ц.Алтангэрэл	ДЦС-4	
	Б.Мөнхтулга	ДЦС-4	

7

Хэмжилтийн ажлын товч танилцуулга

- Улаанбаатар хотод байрлах томоохон эх үүсвэр болох 3 ДЦС-ын зуухнууд, том оврын 50 гаруй УХЗ, гэрийн энгийн зуух, мөн сайжруулсан бүрэн шаталттай зуухнуудад хаягдал утааны хийн хэмжилтийг 2010-2011 болон 2011-2012 оны халаалтын улиралд зохион байгуулсан бөгөөд тус хэмжилтийн дүнг товч танилцуулья.



8

Хэмжилтэнд баримталсан стандарт

Хэмжилтийг хийх үндсэн аргачлал нь “MNS-5457-2005 Халаалтын болон гэрийн зуухны яндангаар гарах утааны хийн найрлага дахь агаар бохирдуулагч бодисын (CO, SO2, NOx, үнс) хүлцэх хэмжээ ба хэмжих арга” гэсэн стандартын мөрдөж ажилласан ба хэмжилтийн үр дүнг дээрхи стандарт мөн “MNS 5919-2008 “Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга” стандарттай харьцуулсан болно.

Хэмжилтэнд төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хаягдал утааны хийн багаж тоног төхөөрөмжийг ашигласан болно.

9

Measurement results of NO.2 Power Plant

Measurement Date	19-Jan		21-Jan		17-Feb		18-Feb	
	NO.5(75th)		NO.3(35th)		NO.4(75th)		NO.5(75th)	
Emission Factor	No. of boiler							
	Dust factor for each duct	kg/t	2,9	2,8	18	5,8	4,2	3,4
	Dust factor as a boiler	kg/t	5,8	-	23	-	7,6	-
	SO2	kg/t	-	-	3,3	-	1,26	-
	NOX	kg/t	-	-	0,69	-	0,97	-
Emission Concentration	CO	kg/t	39	-	41	-	1,25	-
	Dust	g/Nm3	1,2	-	5,8	-	1,7	-
	SO2	ppm	-	-	294	-	98	-
	NOX	ppm	-	-	131	-	162	-
	CO	ppm	6500	-	8400	-	220	-
Emission Standard Value (MNS)	Dust	g/Nm3	21	-	10,6	-	21	-
	SO2	ppm	676,1	-	619,5	-	676,1	-
	NOX	ppm	948,3	-	530,1	-	948,3	-
	CO	ppm	2838	-	70	-	2838	-

10

Measurement results of NO.3 Power Plant


Measurement Date	7-Dec		9-Dec		16-Dec		17-Dec	
No. of boiler	NO.10(220th)		NO.7(220th)		NO.6(75th)		NO.4(75th)	
Emission Factor	Dust factor for each duct	kg/t	0,53	1,2	1,68	2,07	1,05	2,1
	Dust factor as a boiler	kg/t	1,7	-	-	-	3,1	8,6
	SO2	kg/t	-	-	-	-	-	6,1
	NOX	kg/t	-	-	-	-	-	1,99
Emission Concentration	CO	kg/t	-	-	-	-	11,0	124
	Dust	g/Nm3	0,49	0,67	0,42	-	0,95	-
	SO2	ppm	-	-	-	-	252	-
	NOX	ppm	-	-	-	-	175	-
	CO	ppm	-	-	1300	-	12000	-
Emission Standard Value (MNS)	Dust	g/Nm3	10,8	10,8	21	-	1,2	-
	SO2	ppm	519,8	519,8	676,1	-	215,3	-
	NOX	ppm	821,3	821,3	948,3	-	238,9	-
	CO	ppm	240	240	2838	-	4996	-

11


Measurement results of NO.4 Power Plant

